

10 ДУГААР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ
ХУГАЦАА-60
минут

Санамж: Өгөгдсөн даалгаврын зааврыг анхааралтай уншиж зөв хариултаа дугуйлаарай.
1-р хэсэг: сонгох даалгавар нийт 30 оноотой.
2-р хэсэг: харгалзуулах даалгавар тус бүр 1 оноотой.

“А” хувилбар

1. Хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдлийг юу гэдэг вэ? /1 оноо/
а. Бүлэг б. Нийгэм с. Үндэстэн d. Гэр бүл e. Нийтлэг
2. Нийгэмшилтийн явцад хувь хүн өөрийгөө нийгмийн тодорхой бүлэг, нийтлэг, нийгэмд харьяалуулан, тэрхүү бүлэг, нийтлэг, нийгмээ илэрхийлэгч онцлог шинжийг нь тээгч нь болдог. Үүнийг ямар ойлголтоор илэрхийлдэг вэ? /1 оноо/
а. Нийгэмшилт б. Адилсал с. Тээгч d. Нийгмийн нийтлэг e. Бүлэг
3. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлвийг нийгмийн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
а. Аялдах үйлдэл б. Нийгмийн хяналт с. Нийгмийн гажуудал d. Гэмт хэрэг
e. Нийгмийн зан үйл
4. Тоон судалгааны аргад аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
а. Таамаглалыг шалгахаар зорих ба цөөн тооны хувьсагчийн хамаарлыг алгахад анхаарна.
б. Хэмжилтийг мэдээлэл цуглуулахаасаа өмнө хийж, авах мэдээллээ стандартчилна.
с. Мэдээлэл цуглуулах үйл явц нэг ижил горимоор явагдах ба мэдээлэл нь тоогоор илэрхийлэгдэнэ.
d. Математик статистикийн аргуудаар шинжилгээ хийх ба стандарчлагдсан загварын дагуу үр дүнг нэгтгэн бичнэ. e. Дээрх бүгд хамаарна.
5. Соёл судлал нь..... зууны эхэн үед бие даасан шинжлэх ухаан болжээ. Тохирох хариуг дугуйлна уу? /1 оноо/
а. ХҮII б. ХҮIII с. XIX d. XX e. XXI
6. Нийт хүн төрөлхтний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарууд бөгөөд сайн үйл, эрх чөлөө, шударга ёсыг ямар ч ард түмэн эрхэмлэдэг. Энэ нь: /1 оноо/
а. Үнэлэмж б. Үнэлэмжийн баримжаа с. Үнэлгээ d. Үнэт зүйл e. Тохирох хариулт алга
7. Соёлыг бүрдүүлэгч элементүүдийг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /2 оноо/
а. Бэлгэ тэмдэг б. Хэл с. Мэдлэг d. Нийгэмшилт e. Үнэлэмж
8. Соёлыг олон янзаар ангилж болдог. Тэгвэл олон улсын соёл, улс үндэстний соёл гэсэн ангилал нь: /1 оноо/
а. Соёлын түвшин б. Соёлын бүсчлэл с. Соёлын үнэ цэнэ
d. Соёлын диверсификаци e. Соёлын шинэчлэл
9. “Хүний үндсэн эрх, хувь хүний нэр төрд итгэх итгэлийг дахин батлах...” гэсэн зорилготой НҮБ хэдэн онд байгуулагдсан бэ? /1 оноо/
а. 1924 он б. 1940 он с. 1945 он d. 1948 он e. 1992 он
10. Эрх зүйд захирагдах ёсны түгээмэл 4 зарчимд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
а. Засгийн газар, төрийн албаны байгууллагууд хувь хүн, хувийн хэвшлийн байгууллагууд бүгд адилхан хуулийн дор хариуцлага хүлээнэ.
б. Хууль нь хэн бүхэнд ойлгомжтой, хувийн өмчтэй байх, нийтэд тэгш үйлчилдэг байх зэрэг суурь хүний эрхүүдийг хамгаалах ёстой.
с. Тэгш байдлыг хангах

- d. Хууль хүчин төгөлдөр болох, хэрэгжих, үйлчлэх үйл явц нь хүртээмжтэй, шударгаа, үр дүнтэй байх
- e. Шүүхийн байгууллага нь чадварлаг, ёс зүйтэй, мэргэжилтнүүд нь тухайн газрын иргэдийн дунд хүрэлцэхүйц тоо хэмжээтэй байх
11. Эрх зүйн бүрэн бус чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ? /1 оноо/
- a. 14-18 хүртэлх насны хүүхэд b. 18- аас дээш насны хүмүүс
- c. 7-14 хүртэлх насны хүүхэд d. 7 хүртэлх насны хүүхэд e. 16 хүртэлх насны хүүхэд
12. Иргэний эдлэх эрх, үүрэгт аль өгөгдөл нь хамаарахгүй вэ? /1 оноо/
- a. Хүний эрх, эрх чөлөө b. Өргөдөл, гомдол гаргах эрх c. Мэдэх эрх буюу мэдээлэл олж авах, хүртэх
- d. Хүссэн мэдээллийг өгөх үүрэг e. Дээрх бүгд хамаарна
13. Иргэний эрх зүйн харилцаа нь субъект, объект, агуулга гэсэн бүрдэл хэсгүүдтэй. Дараах өгөгдлөөс аль нь иргэний эрх зүйн харилцааны объектод хамаарах вэ? /1 оноо/
- a. Иргэд хоорондын харилцаанд оролцож, хуулийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээж буй этгээд
- b. Эрх зүйн чадвар, чадамжтай этгээд
- c. Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс
- d. Талууд тэгш эрхийн үндсэн дээр бий болсон тэдний эрх үүрэг
- e. Үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох эрх зүйн үр дагавар
14. Хөдөлмөрийн гэрээнд тусгагдах гол нөхцөлүүдийг дурдахдаа алдаа гаргасан бол олно уу?
- a. Ажлын байрны буюу албан тушаалтны нэр
- b. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг
- c. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ
- d. Хөдөлмөрийн нөхцөл
15. ДНБ-ийг тодорхойлохдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/
- a. Эцсийн бараа үйлчилгээний зах зээлийн үнийн дүн
- b. Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэсэн байх
- c. Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх
- d. Тухайн жилд үйлдвэрлэсэн боловч борлогдож амжаагүй бүтээгдэхүүний үнэ
- e. Эдийн засгийн салбар дах хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй байх
16. Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр тодорхойлох аргыг гэнэ. /1 оноо/
- a. ДНБ-ийг орлогоор тооцох b. ҮНБ-ийг зардлаар тооцох
- c. ДНБ-ийг зардлаар тооцох d. ҮНБ-ийг орлогоор тооцох e. Нэрлэсэн ДНБ-ийг орлогоор тооцох
17. Монгол улсын иргэн Япон улсад ажил эрхэлдэг бол түүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн эцсийн дүн хэрхэн тооцогдох вэ? /1 оноо/
- a. Япон улсын ДНБ, Монгол улсын ҮНБ b. Япон улсын ҮНБ, Монгол улсын ДНБ
- c. Япон улсын ДНБ, Японы ҮНБ d. Япон улсын ҮНБ e. Монгол улсын ДНБ
18. Хилийн чанад дахь Монгол улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөгийг эдийн засгийн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
- a. ДНБ b. ҮНБ c. Цэвэр экспорт d. Нэрлэсэн ДНБ e. Бодит ДНБ
19. ДНБ-ийг орлогоор тооцоход аль өгөгдөл нь хамаарах вэ? /1 оноо/
- a. Цалингийн орлого /W/ b. Түрээсийн орлого / R / c. Зээлийн хүүгийн орлого //
- d. ААН-ийн ашиг /P/ e. Дээрх бүгд хамаарна.
20. МоАХ-ны анхны цуглаан хэзээ, хаана болсон бэ? /1 оноо/
- a. 1989.12.10 Залуучуудын соёлын төв ордон, ордны өмнөх хэсэг
- b. 1989.12.20 Сүхбаатарын талбай
- c. 1989.12.10 Эрх чөлөөний талбай d. 1989.12.08 Богд хааны музей
21. Олон түмэн өөрөө өөрийгөө удирдах хэлбэр бөгөөд Эртний Грект иргэн бүрийг төрийг удирдах хэрэгт оролцуулдаг ардчилсан төрийн хэлбэр анх үүссэн юм. Энд ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ? /1 оноо/
- a. Сонгодог ардчилал b. Шууд ардчилал c. Элит ардчилал

- d. Төлөөллийн ардчилал e. Олон ургальч ардчилал
22. МУ-ын гүйцэтгэх эрх мэдлийг хэн тэргүүлдэг вэ?
 А. Ерөнхийлөгч В. Ерөнхий сайд С. УИХ-ын дарга D. Яамдын сайд нар
23. Улс төрийн намууд, нийгмийн бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам бөгөөд хэн нэгний эрх ашгийг хөсөрдүүлдэггүй давуу талтай ардчиллын зарчим аль нь вэ? /1 оноо/
 a. Нээлттэй зарчим b. Шууд ёсны зарчим c. Хууль дээдлэх зарчим
 d. Цөөнхийг хүндэтгэх зарчим e. Зөвшилцлийн зарчим
24. 1990 оноос өмнө Монгол улс үзэл суртал, төрийн дэглэмийн хувьд ямар улс байсан бэ?
 А. Социалист үзэл сурталтай, ардчилсан дэглэмтэй
 В. Социалист үзэл сурталтай, тоталитар дэглэмтэй
 С. Олон ургальч үзэл сурталтай, тоталитари дэглэмтэй
 D. Олон ургальч үзэл сурталтай, авторитари дэглэмтэй.
25. “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц баталгааг бүрдүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хүлээнэ” гэсэн хуулийн заалт ямар хуулинд тусгагдсан байдаг вэ?
 А. МУ-ын үндсэн хууль В. МУ-ын Хүний эрхийн тухай хууль
 С. МУ-ын ардчиллын тухай хууль D. МУ-ын Иргэний эрхийн тухай хууль
26. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбарыг хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
 a. Дипломат харилцаа b. Гадаад харилцаа c. Олон талт харилцаа
 d. Олон улсын харилцаа e. Дипломат бус харилцаа
27. Бүрэн эрхт улс ямар тохиолдолд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг вэ? /1 оноо/
 a. Европын холбоонд элссэнээр b. НҮБ-ын гишүүн болсноор
 c. Хөрш улсууд хүлээн зөвшөөрсөн үед
 d. Аюулгүй байдлаа хамгаалсан тохиолдолд e. Олон ургальч ардчиллыг хэрэгжүүлснээр
28. “Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахдаа шат дарааллыг эрхэмлэсэн, Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэсэн байна ” Энэ нь Монгол улсын гадаад бодлогын аль зарчим бэ? /1 оноо/
 a. Тэнцвэртэй байх b. Идэвхтэй байх c. Үндэсний эрх ашигт нийцсэн байх
 d. Олон тулгуурт байх e. Шат дараалсан байх
29. Монгол Улсын гадаад бодлогын хэд хэдэн зарчмууд бий. “Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах шаардлага нь” аль зарчимд хамаарах вэ? /1 оноо/
 a. Тэнцвэртэй байх b. Идэвхтэй байх c. Үндэсний эрх ашигт нийцсэн байх
 d. Олон тулгуурт байх e. Шат дараалсан байх
30. ОУ-ын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос зудын гамшигт нэрвэгдсэн аймгуудад туслав. Үүнд дурдаж буй ОУ-н Улаан загалмайн нийгэмлэглэг ОУХ-ны ямар оролцогч вэ? /1 оноо/
 А. Их улс оролцогч В. Дунд улс оролцогч С. Сонгодог бага улс оролцогч
 D. Улс бус оролцогч

2-р хэсэг: ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

2.1. Зөв харгалзуулаарай

1	Анхдагч нийгэмшилт буюу дасан зохицлын шат	А	Нийгмийн туршлагыг хэрэглэх төдийгүй түүнд нөлөөлж, бүтээлцэн хөдөлмөрлөж байдаг үе. Энэ шатанд насанд хүрсэн хүний амьдрал, хөдөлмөрийн үйл ажиллагааны бүхий л хэлбэр хамрагддаг.
2	Бодьгалжих шат	В.	Өөрийн эзэмшсэн нийгмийн туршлагыг хойч үедээ дамжуулан уламжлуулах үе

3	Интеграцийн шат	С	Нийгэмд эзлэх байр сууриа эрж хайх эрмэлзлийн үе. Энэ шатанд тухайн хүнийг нийгэм, бүлгээрээ хүнлэг байдлаар хүлээн авбал сайн сайхнаар интеграцийн шатанд ордог.
4	Хөдөлмөрийн шат	D	Хүүхэд төрсөн цагаасаа эхэлж, өсвөр нас хүртэлээ нийгмийн туршлагыг шүүмжлэхгүйгээр хүлээн авч дасах шат
5	Хөдөлмөрийн дараах шат	E	Нийгмийн зан үйлийн хэм хэмжээнд шүүмжлэлтэй хандаж, бусдын дунд өөрийгөө илэрхийлэх хүсэл эрмэлзэлтэй болох шат. 18-25 насанд бие хүний шинж чанар тогтвортой бүрэлдэж, нийгэмшлийн чиг хандлага тогтдог.

2.2. Соёлын чиг үүргийг зөв харгалзуулаарай

1	Соёлын үзэгдлүүд тэмдгэн хэлбэрээр оршдог	a	Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг
2	Хүмүүс амьдралын чиг баримжаагаа олж байдаг	b	Үйл ажиллагааны чиг үүрэг
3	Соёл нь нийтлэг итгэл үнэлшил, үнэлэмжийн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийг нэгтгэдэг	c	Бэлгэдлийн чиг үүрэг
4	Өмнөх үеийн бүтээсэн нийгэм- соёлын уламжлалыг өвлүүлэх нь нийгмийн оршихуйн үндэс	d	Нэгтгэн зохицуулах чиг үүрэг

2.3. Зөв тохируулна уу?

1	Эрх зүйн субъект	A	Хуулиар олгогдсон эрх эдэлж үүрэг хүлээж буй иргэд.
2	Эрх зүйн объект	B	Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хамаарна.
3	Эрх зүйн агуулга	C	Талуудын тэгш эрхийн үндсэн дээр тэдний эрх үүргээр тодорхойлогддог.

2.4. Зөв тохируулна уу?

- | | |
|-----------|--|
| 1. 16 нас | A. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажил хийж болно. |
| 2. 15 нас | B. Эцэг эхийн зөвшөөрлөөр хөдөлмөрийн гэрээ байгуулахыг зөвшөөрнө. |
| 3. 14 нас | C. Мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. |

2.5. Ардчиллын үнэт зүйлсийг утга санаатай нь зөв тохируул.

1	Иргэдийн улс төрийн оролцоо	A	Олон ургальч үзлийг хөгжүүлэх үндэс болж олон нам, нэрдэвшигчдийн улс төрийн бодлогоос сонгох боломж олгодог.
2	Нийтэд тайлагнах, ил тод байх ёс	B.	Төрийн албан хаагчдын авлигалаас урьдчилан сэргийлэх.
3	Олон намын тогтолцоо	C.	Албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээх

4	Эрх мэдлэ э хэтрүүлэхэд хяналт тавих	D.	Иргэд сонгуульд саналаа өгөх, нэрээ дэвшүүлэх, сонирхлын бүлэгтэй хамтран ажиллах, жагсаал цуглаан хийх, төрийн байгууллага, албан тушаалтанд хандан захидал бичих, санал хүсэлт тавих зэрэг олон хэлбээрээр хэрэгждэг.
5	Тогтмол, чөлөө тшударга сонгууль	E.	Ардчиллын амин сүнс бөгөөд бүх нийтийн, нууц, шууд гэсэн зарчимд үндэслэдэг.

2.6. Төрийн байгууллагуудын эрх зүйн актыг зөв тохируулна уу.

1	МУ-ын ерөнхийлөгч	A	Захирамж
2	МУ-ын Их хурал	B	Тогтоол
3	МУ-ын Засгийн газар	C	Хууль
4	Засаг дарга	D	Зарлиг

2.7. Өгөгдлийг зөв харгалзуулаарай.

1	Хөдөлмөрийн зах зээл	A	Хөдөлмөрийн чадвартай хүн ам
2	Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт	B	Ажиллах хүчний арилжаа солилцоо явагдаж буй хүрээ
3	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт	B	Ажиллах хүчинд төлж байгаа цалингийн түвшин
4	Хөдөлмөрийн зах зээлийн үнэ гэдэг нь	Г	ААН-үүдээс санал болгож буй ажлын байр

2.8. Инфляцид холбогдох ойлголтуудыг зөв харгалзуулна уу.
оноо/

/5

1	Инфляци	A	Үйлдвэрлэлийн чухал нөөцүүдийн үнэ, эсвэл цалин өсөх үед бүтээгдэхүүний үнэ дагаж өсөх үзэгдэл
2	Эрэлтээс үүдэлтэй инфляци	B	Бараа, бүтээгдэхүүний үнэ огцом, түргэн бөгөөд жигд бусаар өсөх үзэгдэл. Тухайлбал инфляци 54.2 %-д хүрсэн
3	Зардлаас үүдэлтэй инфляци	C	Нийт эрэлтийн хэмжээ нь нийт нийлүүлэлтийн хэмжээнээс давж үнэ өсөх үзэгдэл
4	Мөлхөө инфляци	D	Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдэл
5	Цогио инфляци	E	Бараа, бүтээгдэхүүний үнэ аажмаар хэлбэрэлтгүй өсөх үзэгдэл. Тухайлбал инфляци 4.7%-д хүрсэн

2.9. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчим, агуулгыг зөв харгалзуулаарай

1	Үндэсний эрх ашиг аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс аль болох олон улс оронтой хамтран ажиллах, гадаад харилцааг олон хэлбэрээр явуулах	a	Тэнцвэртэй байх
2	Үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх	b	Олон тулгуурт байх
3	Гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах	c	Үндэсний эрх ашигт нийцсэн байх
4	Стратегийн зорилтыг хэрэгжүүлэхдээ шат дарааллыг эрхэмлэсэн, стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн эдийн засаг болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэх	d	Прагматик байх

2.10. Зөв тохируулна уу?

- | | |
|--|-----------------------------|
| 1.Олон улсын байгууллага байгууллагууд | A. НҮБ тэргүүтэй олон улсын |
| 2.Олон улсын төрийн бус байгууллага | B. Эмнэсти Интернэйшнл |
| 3.Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ | C.BBC, CNN |
| 4.Үндэстэн дамнасан корпорацууд | D.Тоёото, Walmart |
| 5.Нөлөө бүхий хувь хүн | E.Далай лам |

10 ДУГААР АНГИЙН НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

ХУГАЦАА-60 минут

Санамж: Өгөгдсөн даалгаврын зааврыг анхааралтай уншиж зөв хариултаа дугуйлаарай.
1-р хэсэг: сонгох даалгавар нийт 30 оноотой.
2-р хэсэг: харгалзуулах даалгавар тус бүр 1 оноотой.

“В” хувилбар

Сонгох даалгавар:

1. Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхүйн тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтад орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралынх нь хэлбэрийг юу гэдэг вэ? /1 оноо/
а. Бүлэг б. Нийгэм с. Үндэстэн d. Гэр бүл е. Нийтлэг
2. Нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
а. Нийгэмшилтийн бүрдэл б. Нийгэмшилтийн агент с. Нийгэмшилтийн объект
d. Нийгэмшилтийн субъект е. Нийгэмшилтийн нөөц
3. Нийгмийн хэм хэмжээ, хүлээлтэд нийцэх төлвийг нийгмийн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
а. Аялдах үйлдэл б. Зохистой үйлдэл с. Харилцан үйлдэл d. Харилцан үйлчлэл
4. Чанарын судалгааны аргад аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
а. Мэдээллийн утгыг ойлгох, дүрслэн харуулахаар зорих ба судлагдагчийн яриа, үйлдлээс хамаарсан олон тооны хувьсагч байна.
б. Хэмжилт нь мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь явагдана
с. Мэдээлэл цуглуулах үйл явц харилцан адилгүй явагдах бөгөөд задгай мэдлэгээс ерөнхий сэдэв, нотолгоог олж авахад дүн шинжилгээ чиглэнэ.
d. Стандартлагдсан загварын дагуу үр дүнг бичих албагүй. е. Дээрх бүгд хамаарна.
5. гэдэг нь "cultura" латин хэлний "соёолуулан боловсруулах, хөрс боловсруулах" гэсэн утгыг илтгэдэг. /1 оноо/
а. Соёл б. Дэд соёл с. Нийтийн соёл d. Ардын соёл е. Урлаг
6. Соёлыг хүмүүст амьдралын үйл ажиллагааны хэв загваруудаас сонгох боломж бүрдсэн эсэхээс хамаарч хэрхэн ангилдаг вэ? /1 оноо/
а. Нэг хэв загварын болон олон хэв загварын соёл б. Ардын, сонгодог, нийтийн соёл
с. Зонхилогч, дэд, сөрөг соёл d. Олон улсын соёл, улс үндэстний соёл
е. Сонгомол, бага, хээнцэр соёл
7. Орчин үеийн олон улсын соёлын бодлогын чиглэлд аль нь хамаарах вэ? /1 оноо/
а. Соёлын зорилго, чиглэл хөгжлийн хандлагыг хүний хөгжилд чиглүүлэх
б. Соёлын үйл ажиллагаанд хүн бүрийн оролцоог хангах
с. Үндэстэн, ястны соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах
d. Соёлын харилцааг нээлттэй байлгах е. Дээрх бүгд хамаарна
8. Соёлын түүхэн хэв маягийн ангилалд хамаарахгүй олно уу? /1 оноо/
а. Хүй нэгдлийн, эртний соёл б. Дундад зууны, сэргэн мандалтын соёл
с. Шинэ үеийн, орчин үеийн соёл d. Өрнийн, Дорнын соёл
е. Түүвэрлэгчдийн, нүүдэлчдийн соёл
9. Дараах бодомжуудаас бурууг олно уу? /1 оноо/
а. Хүний эрхэм чанар нь хүн бүрд адилхан байдаг
б. Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж бодоггүй с. Хүний эрхэм чанарт халдаж болохгүй
d. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл е. Алдаатай бодомж алга
10. НҮБ хэдэн онд "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" хэмээх баримт бичгийг батлан гаргасан бэ? /1 оноо/

- a. 1924 он b. 1940 он c. 1945 он d. 1948 он e. 1992 он
11. Эрх зүйн заримдаг чадамжтай хүн гэж хэнийг хэлэх вэ?
 a. 14-18 хүртэлх насны хүүхэд b. 18- аас дээш насны хүмүүс
 c. 7-14 хүртэлх насны хүүхэд d. 7 хүртэлх насны хүүхэд e. 16 хүртэлх насны хүүхэд
12. Нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдож хүсэл зоригоо тодорхой илэрхийлсэн илэрхийллийггэнэ. /1 оноо/
 a. Хэлцэл байгуулах санал b. Гэрээ байгуулах санал
 c. Нэхэмжлэл гаргах санал d. Тохиролцоо хийх e. Хүсэлт гаргах
13. Иргэний эрх зүйн харилцаа нь субъект, объект, агуулга гэсэн бүрдэл хэсгүүдтэй. Дараах өгөгдлөөс аль нь иргэний эрх зүйн харилцааны агуулгад хамаарах вэ? /1 оноо/
 a. Иргэд хоорондын харилцаанд оролцож, хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээж буй этгээд
 b. Эрх зүйн чадвар, чадамжтай этгээд
 c. Эдийн баялаг болох эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс
 d. Талууд тэгш эрхийн үндсэн дээр бий болсон тэдний эрх үүрэг
 e. Үйлдлээр эрх олж авах, үүрэг бий болгох эрх зүйн үр дагавар
14. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа хэнд чиглэгдэх вэ? /1 оноо/
 a. Өндөр настанд b. Нийгмийн бүх гишүүдэд
 c. Ажилгүй иргэдэд d. Эх, хүүхэд e. Ядуу амьдралтай иргэнд
15. ДНБ гэж юуг хэлэх вэ? /1 оноо/
 a. Үндэсний нийт бүтээгдэхүүнээс үйлдвэрлэлийн явцад элэгдсэн капиталын элэгдлийн шимтгэлийг хасах
 b. Тухайн жилд нийт үйлдвэрлэлээс олсон орлогын нийлбэр
 c. Дотоод бол гадаад дахь хөрөнгө оруулалттай ААН-үүдийн нэг жил үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
 d. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа үйлчилгээний зах зээлийн үнийн дүн
 e. Үндэсний цэвэр бүтээгдэхүүнээс худалдаа үйлчилгээний шууд бус татварыг хасаад үлдэх хэсэг
16. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр тодорхойлох аргыг гэнэ. /1 оноо/
 a. ДНБ-ийг орлогоор тооцох b. ҮНБ-ийг зардлаар тооцох
 c. ДНБ-ийг зардлаар тооцох d. ҮНБ-ийг орлогоор тооцох
 e. Нэрлэсэн ДНБ-ийг орлогоор тооцох
17. ДНБ -ийг орлогоор нь тодорхойлохдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 a. Цалин b. Түрээсийн төлбөр c. Эрх гэрийн хэрэглээний зардал d. Зээлийн хүү
 e. ААН-ийн ашиг
18. Орос улсын иргэн Монгол улсад ажил эрхэлдэг бол түүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн эцсийн дүн хэрхэн тооцогдох вэ? /1 оноо/
 a. Орос улсын ДНБ, Монгол улсын ҮНБ b. Орос улсын ҮНБ, Монгол улсын ДНБ
 c. Орос улсын ДНБ d. Орос улсын ҮНБ e. Монгол улсын ДНБ
19. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөгийг эдийн засгийн шинжлэх ухаанд хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
 a. ДНБ b. ҮНБ c. Цэвэр экспорт d. Нэрлэсэн ДНБ e. Бодит ДНБ
20. “Demos cratos” гэсэн үг утга гарлын хувьд доорх өгөгдлүүдээс алинд нь тохирч байна вэ? /1 оноо/
 a. “Ардчилал”, грек үг b. “ Шууд ардчилал”, англи үг
 c. “Ард түмэн”, грек үг d. “Засаглал”, латин үг e. “Төр улс”, франц үг
21. Иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтаныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр юм. Энд ардчиллын аль хэлбэрийн тухай өгүүлсэн байна вэ? /1 оноо/
 a. Сонгодог ардчилал b. Шууд ардчилал c. Элит ардчилал
 d. Төлөөллийн ардчилал e. Олон ургальч ардчилал
22. Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын гаргадаг эрх зүйн акт аль нь вэ? /1 оноо/

a. Тушаал, дүрэм b. Хууль c. Тогтоол, захирамж d. Зарлиг e. Шийдвэр, тушаал

23. МУ-ын гүйцэтгэх эрх мэдэлд хамаарахгүй субъектийг олно уу?
 А. Засгийн газар-ерөнхий сайд В. УИХ-ын дарга
 С. Яамдууд, сайд нар D. Бүх шатны засаг дарга нар
24.бол төрийн эрх барих дээд байгууллага юм.
 А. Ерөнхийлөгч В. Ерөнхий сайд С. УИХ D. Яамдын сайд нар
25. Нэг цонхны үйлчилгээ, Төрийн үйлчилгээний цахим машин, Иргэдийг хүлээн авах төв гэсэн шинэ хэлбэрүүдээр төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх болсоны гол зорилго юу вэ?
 А. Төрийн үйлчилгээг саадгүй хүргэх зорилготой.
 В. Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, чирэгдэлгүй, шуурхай хүртээмжтэй болгох зорилготой. С. Төрийн үйлчилгээг ухаалаг, цахим болгох зорилготой.
 D. Төрийн үйлчилгээг хурдан, цахим болгох зорилготой.
26. “Нэгдсэн Үндэстний байгууллага “ улс бус оролцогчдын аль ангилалд хамаарах вэ? /1 оноо/
 a. Олон улсын байгууллага b. Нөлөө бүхий хүн c. Террорист, зэвсэгт бүлэглэлүүд
 d. Олон улсын төрийн бус байгууллага e. Шашны байгууллага
27. Олон улсын харилцаанд оролцогчдын хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоог хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/
 a. Олон улсын эрх зүй b. Олон улсын иргэний эрх зүй c. Олон улсын эрүүгийн эрх зүй
 d. Императив эрх зүй e. Диспозитив эрх зүй
28. Элч төлөөлөгч солилцох, төрийн тэргүүний айлчлал хамтарсан уулзалт зэрэг нь Монгол улсын төрийн ямар бодлого вэ? /1 оноо/
 А. Эдийн засгийн бодлого В. Төрийн гадаад бодлого
 С. Төрийн дотоод бодлого D. Аялал жуулчлалын бодлого
29. Монгол улс ОУХ-ны ямар оролцогч вэ? /1 оноо/
 А. Их улс оролцогч В. Дунд улс оролцогч
 С. Сонгодог бага улс оролцогч D. Улс бус оролцогч
30. Манай улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласан он бол:
 А. 1990 он В. 1999 он С. 1992 он D. 2008 он

2-р хэсэг: ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

2.1. Өгөгдлийг зөв харгалзуул.

1	Урамшуулал	А	Дасгалжуулагч дасгалаа орхисон багийн гишүүнээ ололт амжилтаа хадгалахын чухалд итгүүлэх
2	Шийтгэл	В	Эвлэрлийг хөхүүлж, гажуудлыг дам буруушаадаг
3	Итгэл үнэмшил	С	Гажуудал хэмээн үзсэн зан төлвийг хэвийн гэж үнэлдэг.
4	Хэм хэмжээг хянан үнэлэхүй	D	Гаж үйлдлийн эсрэг дам чиглэдэг. Жнь дургүйцсэн харц
5	Нийгмийн хяналт	E	Нийгмийн бүлгийн олонх гишүүд хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй нийцэх төлөв

2.2. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

	Соёлыг бүрдүүлэгч элементүүд		Агуулга
1	Бэлгэ тэмдэг	А	Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлс.
2	Хэл	В	Тухайн зүйлийнхээ утгыг дамжуулдаг код, дүр төрх эсвэл дуу авиа бөгөөд утга илэрхийлдэг, мөн утгыг бий болгодог.

3	Үнэлэмж	C	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл.
4	Мэдлэг	D	Нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанарууд.

2.3. Зөв тохируулна уу?

1	Гомдол	A	Захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсэн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт.
2	Өргөдөл	B	Тодорхой ажиллагааг эхлүүлэх эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт
3	Хүсэлт	C	Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт бичиг.

2.4. Зөв тохируулна уу?

- | | |
|-----------|--|
| 1. 16 нас | A. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажил хийж болно. |
| 2. 15 нас | B. Эцэг эхийн зөвшөөрлөөр хөдөлмөрийн гэрээ байгуулахыг зөвшөөрнө. |
| 3. 14 нас | C. Мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. |

2.5. Ардчиллын үнэт зүйлсийг утга санаатай нь зөв тохируул.

1	Хүний эрх, эрх чөлөө	A	Иргэн хүн хуулиар баталгаажсан эрх эдлэх
2	Тэгш эрх	B	Ардчиллын үнэт зүйлсүүдийг хэрэгжүүлэх гол хөшүүрэг.
3	Хуулийн засаглал	C	Нийгмийн харилцаанд оролцох боломжийг илэрхийлсэн ойлголт
4	Боловсрол	D	Ямар ч иргэнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйс, үзэл бодлоор нь ялгаварлахгүй байх.
5	Олон намын тогтолцоо	E	Олон ургальч үзлийг хөгжүүлэх үндэс болж олон нам, нэр дэвшигчдийн улс төрийн бодлогоос сонгох боломж олгодог.

2.6. Зөв тохируул.

1	МУ-ын УИХ	A	Төрийн хуулийн биелэлтийг хангана.
2	МУ-ын ерөнхийлөгч	B	Зөвхөн хуульд захирагдана.
3	МУ-ын Засгийн газар	B	Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч
4	МУ-ын шүүх	Г	Хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах

2.7. Эдийн засгийн дараах ойлголтуудыг агуулгатай нь зөв холбоорой

1	Төрийн сангийн бодлого	A	Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого
2	Мөнгө зээлийн бодлого	B	Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх үйл ажиллагаа
3	Гадаад худалдааны бодлого	C	Бусад орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс явуулах бодлого
4	Татвар, татварын бодлого	D	Бүх хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагад заавал төлөх буцалтгүй шинжтэй хураамж

2.8. Ажилгүйдлийн хэлбэрүүдэд тохирох жишээг зөв харгалзуулна уу? /5 оноо/

1	Бүтцийн ажилгүйдэл	A	Иргэдийн худалдан авалт муудаж олон үйлдвэрийн газар хаалгаа барьснаар Хуяг ажилгүй болсон
---	--------------------	---	--

2	Мөчлөгийн ажилгүйдэл	B	Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой уурхай хаагдаж уурхайчид ажлаа алдсан
3	Улирлын ажилгүйдэл	C	Навчаа хүссэн ажлаа хийхийн тулд гадаад хэл сурахаар ажлаас завсардсан
4	Шилжилтийн ажилгүйдэл	D	Сугар барилга дээр ажилладаг ч өвлийн улиралд ажил нь түр хугацаагаар зогссон тул одоо ажилгүй байгаа
5	Байнгын ажилгүйдэл	E	Ажилгүйдлийн ийм хэлбэр байхгүй

2.9. Дараах ойлголтуудыг зөв харгалзуулна уу. /5оноо/

1	Хатуу хүч	A	Улсуудын харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг бататгах буюу үндэсний эрх ашгаа хөхиүлэн дэмжих зорилгоор үзэл санаа, үнэт зүйл, уламжлал зэрэг бусад талуудын солилцоон дээр үндэслэдэг
2	Соёлын дипломат ажиллагаа	B	Ямар ч үед аль ч нөхцөлд ядарч зүдэрсэн эмзэг бүлгийн хүмүүсийн эрх ашгийг дээдэлж, тэдний ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулахыг шийдвэр гаргагчид болон манлайлагчдад уриалах, ятган үнэмшүүлэх явдал
3	Эдийн засгийн дипломат ажиллагаа	C	Хоёр болон олон талт үйл ажиллагаанд тулгуурлан улс орныхоо худалдаа санхүүгийн ашиг сонирхлыг дипломат аргаар хангах явдал
4	Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа	D	Их гүрнүүд цэрэг, эдийн засгийн хүч чадавхдаа тулгуурлан хүчээр түрий барих бодлого хэрэгжүүлэх

2.10. Зөв тохируулна уу?

- | | |
|---------------------------------------|------------------------------------|
| 1.Олон улсын байгууллага | A. Дэлхийн сагсан бөмбөгийн холбоо |
| 2.Олон улсын төрийн бус байгууллага | B. Далай лам |
| 3.Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ | C.BBC, CNN |
| 4.Үндэстэн дамнасан корпорацууд | D. Apple, Google |
| 5.Нөлөө бүхий хувь хүн | E.ACEM, APFA |